



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/536

Хэрлэн сум

“Иргэдийн оролцоот Хэтийн Хэнтэй”  
арга хэмжээ зохион байгуулахад хөрөнгө  
зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Иргэдийн оролцоот Хэтийн Хэнтэй” арга хэмжээний хүрээнд хэсгийн ахлагч нарыг туршлага судлахад зориулж замын зардал болох 3,700,000 (гурван сая долоон зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 12-ны  
А/536 дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Бүгд үнэ
1	Замын зардал	3,700,000
	Нийт	3,700,000